



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/442

Булган сум

**Аймгийн баяр наадмын төсөв
батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Булган аймаг байгуулагдсаны 87 жилийн ой, аймгийн баяр наадмын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Баяр наадмын арга хэмжээний 164,000,000 (нэг зуун жаран дөрвөн сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын тамгын газраас санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010614

Аймгийн Засаг даргын 2025. оны
05 сарын 24 өдрийн 174 дүгээр
захирамжийн хавсралт



Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн
ой, Булган аймаг байгуулагдсаны 87 жилийн ойн баяр наадмын төсөв

№	Зориулалт, арга хэмжээ	Ирүүлсэн санал /мян.төг/	Хянасан төсөв /мян.төг/
1	Үндэсний бөхийн барилдаан	39,488.2	25,900.0
2	Хурдан морины уралдаан	50,877.2	41,916.8
3	Үндэсний сурын харваа	8,595.4	8,000.0
4	Үндэсний шагайн харваа	7,620.0	7,620.0
5	Нийгмийн хэв журам сахиулах арга хэмжээ	16,524.3	13,500.0
6	Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, орчны ариун цэврийн шаардлага хангуулах	1,854.0	1,364.0
7	Нийгэм, соёл, урлагийн арга хэмжээний зардал	115,320.0	49,345.0
8	Аж ахуйн зардал	14,095.0	14,000.0
9	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа	22,248.5	5,354.2
10	Гадаад зочин төлөөлөгчийн зардал	14,217.5	-
11	Засвар, тохижилтын ажил	22,253.5	11,000.0
	Дүн	313,093.6	178,000.0